



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/308

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Агаарын бохирдолтой тэмцэх газрын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Нийслэлийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/766 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /М.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
04 дугаар сарын 15-ны өдрийн
А/30 дугаар захирамжийн хавсралт

АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар (цаашид “Газар” гэх) нь Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, агаарын чанарыг тодорхойлох, агаарын бохирдолд хяналт, шинжилгээ, судалгаа хийх, бохирдуулагч эх үүсвэрүүдээс байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах, дэвшилтэт шинэ технологийг нэвтрүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

1.2.Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

1.3.Газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 7.1-д заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмуудаас гадна төрийн үйлчилгээг чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.4.Газар үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж, тайлагнана.

1.5.Газар зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Төрийн сан банкинд харилцах данстай байна.

Хоёр.Газрын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

2.1.Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтооно.

2.2.Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга, орлогч даргыг Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Газрын дарга тус тус томилж, чөлөөлнө.

2.3.Газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргаар хянуулж, түүний саналыг тусган газрын дарга батална.

2.4.Газрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

2.5.Газрын дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.5.1.батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын тасгийн бодлого, журмын дагуу ажилтнуудыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах;

2.5.2.холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг баталж, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох;

2.5.3.хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм баталж мөрдүүлэх;

2.5.4.архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар санал боловсруулж удирдах дээд байгууллагын албан тушаалтанд танилцуулах;

2.5.5.газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд саналаа Нийслэлийн Засаг дарга, холбогдох бусад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.5.6.сахилга дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

2.5.7.ажилтнуудын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.5.8.нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

2.5.9.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг;

2.5.10.гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтарч ажиллах;

2.6.Газрын дарга, албан хаагчид Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагатай Нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана.

2.7.Газрын дарга хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг тогтоосон хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллана.

Гурав.Газрын үндсэн чиг үүрэг

- X 3.1.Нийслэлийг хөгжүүлэх нийгэм эдийн, эдийн засгийн үндсэн чиглэл хөтөлбөр, тухайн санхүүгийн хугацааны төсвийн төслийг боловсруулахад оролцож, нийслэлийн удирдлагад дараах асуудлуудаар санал боловсруулж, шийдвэрийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- X 3.1.1.агаарын бохирдолтой тэмцэх чиглэлээр Монгол Улсын хууль, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах;
- W 3.1.2.агаарын бохирдолтой тэмцэх арга хэмжээг төлөвлөн улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх;
- W 3.1.3.агаарын чанарын улсын хяналт-шинжилгээний сүлжээний нийслэл дэх нэгжийн тасралтгүй ажиллагааг хангах;
- W 3.1.4.агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх, шилжүүлэх, өөрчлөн байршуулах талаар санал боловсруулж төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж шийдвэрлүүлэх;
- X 3.1.5.нэгжийн агаарын чанарын мэдээллийн санг бүрдүүлэх, агаарын чанарын 7 хоног ба сар тутмын мэдээг нэгтгэн баталгаажуулж мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;
- 3.1.6.агаарт хаягдах хорт бодисын эх үүсвэрүүд, хорт бодисын хэмжээг тодорхойлон хяналт тавьж, бохирдлыг бууруулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах;
- 3.1.7.агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллогыг жил бүр төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу дүүргүүдтэй хамтран зохион байгуулж, дүн мэдээг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэх;
- 3.1.8.агаарын бохирдолтой тэмцэх зорилгоор агаарын чанарыг сайжруулах бүсийг жил бүр шинэчлэн тогтоох саналыг боловсруулах;
- 3.1.9.агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын төслийн санал боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлэх;
- 3.1.10.агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах, нийтэд мэдээлэх;
- 3.1.11.агаарын чанарыг сайжруулах бүсийн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой айл өрхийн гэр, байшинг дулаалах, сайжруулсан зуух, сайжруулсан түлш, хийн түлшээр хангах ажлыг зохион байгуулах;
- 3.1.12.нийслэлийн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа халаалтын зуухыг нэгдсэн болон хэсэгчилсэн дулаан хангамжийн системд холбох, эсвэл байгаль орчинд ээлтэй (саргаарах эрчим хүч, цахиргаан, шийг байгаль

3.1.13. агаар бохирдуулах бодисын агууламж, физикийн сөрөг нөлөөллийн түвшин стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, олон нийтэд шуурхай мэдээлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх;

3.1.14. агаарын бохирдолтой тэмцэх чиглэлээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас санаачилсан арга хэмжээг дэмжих, зөвлөмж өгөх, мэдээллийн санг бүрдүүлэх;

3.1.15. агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох ажлыг зохион байгуулах;

X 3.1.16. агаар бохирдуулах бодис түүний агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэм хэмжээг тогтоох агаарын чанарын стандарт, хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатаах, устгах үйл ажиллагааны улмаас агаарт ялгарах хаягдлын стандартын төслийг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.1.17. агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс баримталж байгаа бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд оролцох, түүний хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах;

3.1.18. стандартын шаардлага хангасан сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжих, нийслэл хотод түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох;

3.1.19. сайжруулсан түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн түлшний чанарт хяналт тавих, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах;

3.1.20. нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан шахмал түлшээр хангах;

3.1.21. нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуухны ашиглалт, түлшний зарцуулалтыг хянах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

X 3.1.22. агаарын чанарыг доройтуулж байгаа бодисын ялгарал, бохирдуулагч эх үүсвэр, физикийн хортой нөлөөлөлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу уг зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

3.1.23. агаар бохирдуулах тодорхой эх үүсвэрүүдийн агаарын бохирдолд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж хэмжилтийн дүнд үндэслэн тэдгээрийг эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад агаарын бохирдлын сөрөг нөлөөллийг бууруулах, технологийн шинэчлэл хийх мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах, мэдээ гаргах;

X 3.1.24.осол гарсан, химийн хордлого үүссэн, агаарын бохирдол ихэссэний улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулж болох нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны технологийн горимыг өөрчлөх, эсхүл бүр мөсөн зогсоох арга хэмжээ авах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх;

3.1.25.агаарын бохирдолтой тэмцэхэд иргэдийн оролцоог хангаж, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хууль, тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

3.1.26.агаарын чанарт нөлөөлж болзошгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орчны агаарын чанарт хэмжилт хийх, үнэлгээ өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх;

3.1.27.агаар бохирдуулах эх үүсвэрүүдийн хэмжилтийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах;

3.1.28.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу орчны агаарын чанар болон агаар бохирдуулах эх үүсвэрийн хаягдал хий тодорхойлох хэмжилтийн ажлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу төлбөрт үйлчилгээ үзүүлэх;

X 3.1.29.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангах;

X 3.1.30.гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

3.2.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Дөрөв.Хариуцлага

4.1.Энэ дүрмийг зөрчсөн буруутай этгээдэд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

5.1.Энэ дүрмийг зохих журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

5.2.Энэ дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.